

УДИРТГАЛ ХЭСЭГ

Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо нь 1967 онд ХАА-н Нэгдлийн Холбооны Дээд Зөвлөл нэртэйгээр байгуулагдаж, 1992 оны 1 дүгээр сард хуралдсан Үндэсний холбооны анхдугаар их хурлаар шинэчлэгдэн зохион байгуулагдсан. Одоогоор 3 шатлал бүхий тогтолцоогоор улсын түвшинд үндэсний холбоо, аймагт салбар холбоод, суманд анхан шатны болон дундын хоршоодыг эгнээндээ нэгтгэсэн Монгол орон даяар өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний төрийн бус байгууллага юм.

Үндэсний холбоонь 2002 онд хуралдсан IV Их хурлаараа “Хөдөө аж ахуйн хоршооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө” –г боловсруулан батлаж урт хугацааны стратегийн 4 зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хоршооллын байгууллагын менежментийг боловсронгуй болгох
2. Хоршооллын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх
3. Хоршоодын эгнээг өргөтгөж, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх
4. Хоршооллын байгууллагын гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх

Бид дээрх урт хугацааны стратеги зорилтуудыг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг 4 жилээр боловсруулан гаргаж мөрдлөг болгон ажилсаны дагуу зохих үр дүнд хүрээд байна.

Өнөөдөр дэлхий дахинд хоршоо нэг орон, тивийн хүрээнээс хальж дэлхий нийтийн шинжтэй болж, ач холбогдлыг нийтээр ойлгож хүлээн зөвшөөрч байна. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдал, хомсдолыг даван туулахад хоршооллын хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэж байна. Хоршоолол нь дэлхий дээр 1 тэрбум хүнийг эгнээндээ нэгтгэн, дэлхийн хүн амын 40 орчим хувь буюу 3 тэрбум хүн хоршооны үр шимийг хүртэж хамгийн өгөөжтэй аж ахуйн хэлбэр гэж тооцогдож байна.

2012 оны 10-р сард Английн Манчестр хотноо хуралдсан Олон улсын хоршоологчдын их хурлаар 2013-2022 оныг “Хоршооллыг дэлхий дахинд хөгжүүлэх 10 жил” болгон зарлаж, 2013-2022 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг батлан гаргасан. Тэрхүү бодлогын баримт бичигт таван зорилтыг дэвшүүлсэн юм. Үүнд:

- Оролцоо
- Тогтвортой байдал
- Нэр төр
- Хууль эрх зүйн орчин
- Хөрөнгө

Эдгээр зорилт тус бүрийг Олон улсын хоршооллын холбоо, түүний гишүүд болон хоршооллын хөдөлгөөн шийдвэрлэх нэн шаардлагатай тэргүүлэх зорилтууд гэж тодорхойлсон.

Хүн ам цөөтэй, өргөн уудам газар нутагтай, газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэл зонхилсон манай орны хувьд нийгэм, эдийн засаг, техник технологийн үсрэнгүй хөгжлийн өнөө үед илүү бүтээлч, санаачилгатай хамтарч ажиллах нь хөгжлийн нэн чухал асуудал болоод байна. Иймд манай байгууллага энэхүү Олон улсын хоршооллын холбооны бодлогын баримт бичигтэй уялдуулан өөрийн орны онцлогт тохируулсан 2014-2022 онд хэрэгжүүлэх ХАА-н хоршооллын бодлогыг боловсруулан ХАА-н хоршооллын эрчтэй хөгжлийн жилүүд болгох зорилтын үүднээс Та бүхэнд өргөн дэвшүүлж байна.

Нэгдүгээр бүлэг.

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

1.1 Монголын хөдөө аж ахуйн хоршооллын хөгжлийн өнөөгийн байдал

Төрөөс хоршооны эрх зүйн ба бодлогын баримт бичгүүдийг батлаж, хэрэгжүүлснээр хөдөө аж ахуйн хоршоолол хөгжих орчин сайжирч байна. 2013 оны эхний хагас жилд орон даяар зохион байгуулсан малчдын хоршооны сургалтын үеэр авсан судалгаанаас үзвэл: орон нутагт нийт 2144 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн 1508 буюу 70 орчим хувь нь ХАА-н хоршоо байна. Эдгээр хоршоод ихэвчлэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, ханган борлуулалт, түүхий эд бэлтгэл, мал эмнэлэг үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 48.5 хувь нь 9 гишүүнтэй байна. Хоршоо хэт жижиг, ах дүү хамаатны явцуу хүрээнд ажиллаж байгаагаас давуу байдлаа бусдад харуулж чадахгүй байна. Хоршоод өнөөдөр хэдэн ажлын байр бий болгосон, хэдий хэмжээний үйлдвэрлэл, борлуулалт хийдэг, ДНБ-д ямар хувь эзэлдгийг бодитоор илэрхийлэх мэдээ байхгүй байна. Улсын нэгдсэн статистик мэдээнд хоршооны үйл ажиллагааны үзүүлэлт байхгүй нь нийгэмд хоршооны үнэлэмжийг үгүйсгэн бууруулж байна.

Иймд хоршоодын гишүүдийн тоог сайн дурын үндсэн дээр нэмэгдүүлж, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн ардчилсан удирдлага, хяналтыг хангаж олон улсын хоршооллын зарчимд нийцүүлэн сонгодог утгаар нь хөгжүүлэхэд анхаарна.

Хөдөө аж ахуйн хоршоологчдын бүсийн зөвлөгөөний үеэр хоршоодын төлөөллүүдийн дунд явуулсан судалгаанаас харвал “хоршоод хөрөнгө, санхүүгийн хомсдолтой” (55.6%), “хүний нөөцийн хөгжил, удирдлагын ур чадвар дутмаг” (40.0%), “гишүүдийн оролцоо сул, хоршооны зарчим хангалтгүй хэрэгждэг” (35.6%), “харилцан

итгэлцэл, нэгдмэл зорилго хангалтгүй” (22.2%), “гишүүнчлэл нээлттэй бус” (11.1%) зэрэг олон асуудалтай тулгарч байна.

Эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах, сургалт явуулах, үндэсний болон бүсчилсэн судалгаа, үнэлгээ хийх зэрэг хоршооллын салбарт олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хийгдсэн ажил багагүй бий. Гэвч Монгол улсад хэрэгжиж буй гадны төсөл, хөтөлбөрүүд өөр өөрсдийн арга барилаар үйл ажиллагаагаа явуулдаг, давхардал ихтэй, нэг нь нөгөөгөө үгүйсгэдэг, хөрөнгө мөнгө амлаж зохиомол хоршоо үүсгэдэг, албан бус тогтолцоо бий болгож татвараас зайлсхийдэг зэрэг дутагдалтай талууд байна. Иймд үндэсний хэмжээнд хоршоог хөгжүүлэх нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулан, Засгийн газрын болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг тус хүрээнд зохицуулан хэрэгжүүлэх ажлыг Үндэсний холбоо санаачлан манлайлах болно.

1.2 Хоршоодод тулгамдаж буй асуудлууд

Хоршоог хөгжүүлэх талаар бодлогын олон арга хэмжээ хэрэгжүүлж байгаа хэдий ч дараах асуудлууд тулгамдсан хэвээр байна. Үүнд:

- 1.2.1 Мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчин хөдөө орон нутагт дутагдалтай байна. Иймд хоршооны боловсон хүчнийг сургаж бэлтгэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Хөдөө аж ахуйн гаралтайтүүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх оновчтой тогтолцоо бүрдээгүй.
- 1.2.3 Төрийн бодлогын зарим хүчин зүйлсийн нөлөөгөөр хоршоод өрсөлдөгчидтэйгээ адил нөхцөлд шударгаар өрсөлдөх боломжгүй байна. Тухайлбал завсрын худалдаачид, албан бус бизнес эрхлэгчид, хоршооны гишүүн бус малчид татвар төлдөггүй.
- 1.2.4 Хоршоодын өөрийн хөрөнгө, санхүү бэхжээгүй, бий болгож буй эдийн засгийн үр ашиг бага байгаагаас шалтгаалж гишүүддээ хангалттай үйлчилж чадахгүй байна.

Хоёрдугаар бүлэг.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Олон улсын хоршооллын хөгжлийн чиг хандлага, зарчим, үнэт зүйлс, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны болон Монгол улсын засгийн газраас хоршооны хөгжлийн талаар баримталж буй бодлого, хөдөө аж ахуйн хоршооллын

хөдөлгөөний өнөөгийн байдлыг харгалзан энэхүү баримт бичгийн эрхэм зорилго, тэргүүлэх чиглэлийг тодорхойлов.

Эрхэм зорилго:

Гишүүдийнхээ эрх ашгийг дээдлэн хамгаалж, тэдний идэвхтэй үйл ажиллагаа оролцоондтулгуурлан хөдөөгийн эдийн засаг, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг хангахад манлайлагч байж, хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд оршино.

Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо нь Монгол орноо төлөөлөн Олон Улсын Хоршооллын Холбоонд ажилладаг гишүүн байгууллагын хувьд улс орон, орон нутагт хоршооллын хөдөлгөөний манлайлагч байхыг эрмэлзэж хүн ардын амьдралын түвшин, чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна.

Хоршооны ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, хоршоод үүсэхэд хэрэгцээтэй мэдээлэл, сургалтыг явуулах, тогтвортой үйл ажиллагаатай хоршоодыг зээл, хөрөнгө оруулалтаар дэмжих, хоршоодболон тэдний гишүүдэд тулгарч буй бэрхшээлүүдийг арилгах нь бидний бодлогын голлох хүчин зүйлбайх болно.

Энэхүү бодлогын баримт бичиг хоорондоо харилцан уялдаатай зургаан тэргүүлэх чиглэлээс бүрдэж байна. Үүнд:

- **ХОРШООНЫ УДИРДЛАГА, ГИШҮҮДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ**
- **ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**
- **ХОРШООЛЛЫН НЭР ТӨРИЙГ ӨРГӨХ**
- **ХОРШООНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ**
- **ХОРШООНЫ ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ**
- **ТӨР, ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Эдгээр тэргүүлэх чиглэлүүдийн агуулгад Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, түүний гишүүд болон хоршооллын хөдөлгөөнд шийдвэрлэвэл зохих асуудлууд тусгагдсан болно.

Бодлогын баримт бичгийн тэргүүлэх чиглэл бүр тухайн асуудлуудыг шийдвэрлэхэд зохих арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлсон ба энэхүү зорилтуудыг биелүүлэхийн төлөө Үндэсний холбоо болон аймгийн холбоод үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тэргүүлэх чиглэлүүдийн асуудлуудыг тусган, мөрдлөг болгож 2022 он гэхэд хамтдаа нэгдмэл нэг зорилгодоо хүрэхийг эрмэлзэх хэрэгтэй юм.

2.1 НЭГДҮГЭЭР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. ХОРШООНЫ УДИРДЛАГА, ГИШҮҮДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилт: “Гишүүнчлэлд болон удирдлагын түвшинд оролцох оролцоог шинэ түвшинд гаргаж ирнэ”

Монголын хоршоодын хувьд амжилттай үйл ажиллагаа явуулахын тулд гишүүдийн оролцоо чухал үүрэгтэйг төдийлөн хайхрахгүй байгаа үзэгдэл түгээмэл байна. Хоршооны “гишүүн” болон “гишүүн бус” хүний эрх, хоршооноос авах үйлчилгээ, хүртэх үр өгөөж, ирээдүйн үнэ цэнийг ойлгомжтойгоор харьцуулан тодорхойлж сурталчилан үр дүнд хүрнэ. Хоршоог үүсгэн байгуулахаас эхлээд тогтвортой үйл ажиллагаатай болох бүхий л шатанд гишүүдийн оролцоог өндөр байлгах нь хоршооны хөгжилд чухал үүрэгтэйг онцолж байна. Монгол улсын хоршооны тухай хууль, хоршооллын зарчимд Хоршооллын байгууллагын үйл ажиллагаан дахь гишүүдийн оролцоог дараах байдлаар хангаж ажиллахын тодорхой заасан. Үүнд:

- Хоршооны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох
- Шийдвэр гаргахад гишүүн бүр ижил саналын эрхтэйгээр санал тавих, санал гаргах, шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох
- Хоршооны удирдлагыг сонгох, сонгогдох үйл ажиллагаанд оролцох
- Хоршооны удирдлага, албан ажилтнуудаас зохих дүрэм, журмын дагуу ажиллахыг зөвлөх болон шаардах
- Шаардлагатай үед бүх гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах санал гаргах
- Бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж байх
- Хоршооны үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашиг, орлогоос тогтоосон журмын дагуу ногдол ашиг- хувь хүртэхгэх мэт болно.

Хоршооллын бизнесийн бусад аж ахуйн загваруудаас ялгагдах гол онцлог шинж чанар нь гишүүдийн ардчилсан оролцоо болно.

Гишүүд өөрсдөө хоршооны хамтын эзэд бөгөөд үйл ажиллагаа, ардчилсан зохион байгуулалттайгаар засаглалд нь оролцдог. Гишүүдийнэнэхүү эрх эдлэх үйл явцыг бид **“Оролцоо”** хэмээн нэг үгээр илэрхийлэн, эрх эдлэх боломжийг нь дээшлүүлэхийг тэргүүлэх чиглэл болгов.

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо дараах байдлаар оролцоогоо нэмэгдүүлэх болно. Тухайлбал:

- Гишүүдийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалж, бодлого гаргагч нартнөлөөлөн ажиллах, хоршооллын лобби бүлэг улс, аймаг, сумын түвшинд ажиллахад дэмжлэг үзүүлэх
- Олон Улсын Хоршооллын Холбоо, Азийн Фермүүдийн Холбоо, Зүүн Азийн Хөдөө Аж Ахуйн Бодлогын зөвлөлд гишүүн байгууллагынхаа хувьд үйл ажиллагаагаа идэвхижүүлэх

- Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Олон улсын болон үндэсний хэмжээний уулзалт, хурал зохион байгуулах гэх мэт болно.

Хамтын засаглалын бүтэц нь нийгэм, эдийн засгийн хөгжилд таатай нөлөө үзүүлэх төдийгүй ирээдүйд илүү боломжуудыг нээх, хоршоо хүчирхэг болох гол нөхцөл юм.

Гишүүдийн оролцоондхувь хүн зөвхөн өөрийн эрх ашгийг эрхэм болгох бус, хоршооныхоо эрх ашиг, нэр хүндийг адил түвшинд дээдэлсэн байдлаар хангагдана. Иймд хүмүүст ийм ухамсар, хандлагыг бүрдүүлнэ.

2.2 ХОЁРДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ.ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Зорилт: “Хоршоод тогтвортой байдлын тэргүүлэгч мөн”

Дэлхийн эдийн засгийн хямралд томоохон бизнесийн салбаруудын үйл ажиллагаа доголдож байхад хоршооллын байгууллагууд тогтвортой байж, үйл ажиллагаа нь эрчимжиж байгаа нь хоршоолол тогтвортой байдлыг хангах аж ахуйн хэлбэр гэдгээ дэлхий нийтэд баталлаа. Хоршооны үйл ажиллагааны зорилго нь хүний хэрэгцээнд тулгуурласан болохоор өнөөгийн хүнсний аюулгүйн баталгаа, хомсдол, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтворгүй байдалд хоршоод эерэг нөлөөлөл үзүүлж, “хамтын үнэ цэнэ”-ийн онцлог хэлбэрийг дэлхий дахинаа түгээж байна.

Хоршоо бүх гишүүддээ үр өгөөжөө оновчтой хүртээх аргыг эрэлхийлдэг ба хэн нэгэн давуу өмчлөгчийн ашгийг өсгөх зорилго агуулдаггүй аж ахуйн хэлбэр юм. Иймээс тогтвортой байдлыг бий болгоход хоршооний үүрэг, мөн чанар чухал болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Манай оронд Тогтвортой байдлын гол гарцыг хоршоодтой холбож ойлгохгүй байгаа явдал түгээмэл байна. Иймд бодлогын баримт бичигтэнэ асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тусгаж, идэвхтэй үйл ажиллагаагаар өөрчлөх, хүрээгээ тэлж буй ХАА-н хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлж, улс орны нийгэм, эдийн засгийн болон хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангана.Нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудал болоод байгаа ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хүнсний хомсдлыг арилгах, аюулгүй байдлыг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаархи төрийн бодлоготой нягт уялдуулж энэ дэмжлэгийг хоршоодод түлхүү чиглүүлж ажиллана.

Эдийн засгийн орчны тогтвортой байдал.

Хамтын хүчний давуу талыг ашигласанаж ахуйн хэлбэр илүү тогтвортой байдаг гэдгийг дэлхийн эдийн засгийн хямрал харуулсан билээ. Ашиг олохоос илүү гишүүдийн хэрэгцээ, нийтэд хүрэх хүртээмжийг зорилгынхоо цөм болгосон байдаг нь хоршоод бусад аж ахуйг бодвол хомсдол, хямралд орох эрсдэл багатай байх нөхцөл болдог. Хөгжиж буй манай оронд хоршоод эдийн засгийн тогтвортой байдалд шууд болон шууд бус байдлаар голлох үүрэг гүйцэтгэх болно.

Монгол оронд үйл ажиллагаа явуулж буй хоршоодын дийлэнх хэсэг нь эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй тулгарч байна. Тухайлбал, хоршоо гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг дамжуулан борлуулахад НӨАТ ноогдуулдаг нь дарамт болдог байна. Хоршооны гишүүд бүтээгдэхүүнээ хоршоогоороо дамжуулан зах зээлд борлуулж байгаа нь хоршооноосоо үйлчилгээ авах эрхээ эдэлж, хоршооныхоо үйл ажиллагаанд оролцох үүргээ хэрэгжүүлж байгаа болохоос, зах зээлийн арилжаанд оролцож байгаа явдал биш юм. Иймд ХАА-н хоршоог нэмэгдсэн өртгийн албан татвараасчөлөөлөх буюу тодорхой хувиар хөнгөлөхийн төлөө ажиллана.

Монгол улсын эдийн засаг хурдан өсөлттэй байгаа боловч ядуурлын түвшин хөдөөд хамгийн их буюу 39.8%, сумын төвд 27.5%, аймгийн төвд 30.4%, Улаанбаатар хотод 19.8% байна. 2015 онд ядуурлын түвшинг 18 хувьд хүргэх Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхийн тулд ХАА-н хоршоодыг эдийн засаг, санхүүгийн хувьд дэмжихийн зэрэгцээ санхүүгийн үйлчилгээ үзүүлэх Хоршооллын банк, санхүү, даатгалынбайгууллагатай болохыг Үндэсний холбоо зорьж ажиллана.

Нийгмийн орчны тогтвортой байлал.

Хоршоолол өндөр хөгжсөн орнуудын туршлагаас харахад гишүүдийн нийгмийн асуудлуудыг шийдэхэд хоршоо голлох үүрэг гүйцэтгэхээс гадна нийгмийн хариуцлагыг ухамсарлаж бусдад туслах үйлсэд ихээхэн анхаарч ажилладаг байна. Хоршоо зөвхөн зах зээлийн харилцаанд оролцогчбус мөн төрийн үндсэн үүрэг болох нийгмийн үйлчилгээг үзүүлдэгээрээ бусад аж ахуйгаас ялгагддаг юм.

Хүн төрөлхтний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэдхоршооллын оруулж буй хувь нэмэр их байгааг НҮБ-аас хүлээн зөвшөөрч Улс орнуудын Засгийн газруудад “Хорших хөдөлгөөнийг дэмжих, ялангуяа ядуу болон нийгмийн эмзэг бүлгийнхэнд сайн дурын үндсэн дээр хоршоо байгуулах”-д нь дэмжлэг туслалцаа үзүүлэхийгзөвлөж байна.

Нийт малчдын 90 гаруй хувь нь нийгмийн даатгалд хамрагдаагүй гэсэн үзүүлэлт нь манай орны ХАА-н салбарт ажиллаж буй иргэдийн нийгмийн асуудал баталгаагүй хэвээр байгаагийн илрэл юм. Монгол Улсын Их Хурлаас 2009 онд батласан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, малчдын нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар тодорхой зорилтууд дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо идэвхитэй

оролцоно.Цаашид хөдөөгийн иргэдийн нийгмийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын зорилтуудыг хоршоогоор дамжуулж хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй байх болно.

Монгол Улсын Үндсэн хуулинд Монгол оронд хүмүүнлэг, ардчилсан иргэний нийгэм байгуулах үндсэн зорилт дэвшүүлсэн билээ. Энэ зорилтыг ажил үйлс болгоход иргэний нийгмийн хүчирхэг хөдөлгөөн, байгууллагууд голлох үүрэг гүйцэтгэнэ. Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний холбоо нь нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэж буй үүрэг, олон арван мянган гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн байдал, улс орны хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүтэц зэргээ улам өргөтгөн чанаржуулж иргэний нийгмийн хүчирхэг байгууллага болон төлөвшиж улс орны хөгжил, нийгмийн ардчилалд бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байна.

2.3 ГУРАВДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ.**ХОРШООЛЛЫН НЭР ТӨРИЙГ ӨРГӨХ**

Зорилт: “Хоршооны талаархи зөв “мэдээллийг”-ийг нийгэмд түгээж, хоршооны нэр төрийг баталгаажуулна”

Дэлхий нийтэд хоршоод ардчилсан зарчмаар аж ахуй эрхэлж, зөвхөн өөрийн эрх ашгийн төлөө бус бусдын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болдогийн үлгэр жишээ болов.Манай орны хувьд 1990-ээд оны дунд үеэс шинэ маягийн хоршоолол хөгжиж эхэлсэн түүхтэй ч өдийг хүртэл хоршооллын нийгэмд эзлэх байр суурь, ойлголт, нэр хүнд сул байна. Хоршооллын хөдөлгөөний энэхүү байдлыг өөрчлөхөд чиглэсэн ажлуудыг зохион байгуулж, тус хөдөлгөөний ач холбогдлыг нийтэд илүү хүртээмжтэйгээр хүргэх, хоршооны үнэлэмжийг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.Бид нийгэмд бүхэлд нь танигдаж чадахуйц зөвмэдээллийг буюу хоршооны мөн чанарыг ойлгуулж, өөрийн гишүүн холбоо, хоршоодын эдийн засгийн чадавхийг бэхжүүлж чадсанаар иргэдийн дунд хорших хүсэл сонирхол өрнөж, үндсэн зарчимд нийцсэн хоршоод олноор байгуулагдах суурь тавигдаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд таатай нөлөөлөл үзүүлэх нь дамжиггүй юм.

Хоршоодын үйл ажиллагаагаа явуулах, өмчлөх, үнэлэх, удирдах ёс бусад аж ахуйн хэлбэрээс ялгаатай.Гэвч хоршооллын энэ зарчмыг хэрхэн баримтлаж байгаа нь хоршоод болгонд харилцан адилгүй байна. Иймээс бид хоршоодыг хүчирхэгжүүлж, түүний мөн чанарын талаарх эерэг ойлголтыг оновчтой сувгаар нийгэмд хүчтэй өгч, хоршооны нэр төрийг өндөрт өргөж, хамгаалах нь чухал.Дэлхийн нийт хоршооллын байгууллагууд “хоршоо” гэсэн үгийг урвуу ашиглахаас сэргийлж, энэ нэрний мөн чанарыг хамгаалахыг зорилт болгож байна.

Нэр төрийг өсгөх хамгийн чухал хэлбэр ньодоо байгаа анхан шатны хоршоод бүтээгдэхүүн борлуулалтын чиглэлээр дундын хоршоодыг байгуулах, хоршоодыннийгмийн болон соёлын үйлчилгээг сайжруулах,өөрийн үйл ажиллагаагаа эрчимжүүлж, олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээ явуулах, өөрийн гүйцэтгэж буй үйл ажиллагаагаа бусдад таниулах зорилгоор мэдээлэл хүргэх явдал юм. Иймд Үндэсний

холбоо үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, аймгийн ХАА-н хоршоодын холбооны ажлыг идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбарын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.

Бид өөрсдийн цахим хуудсын www.namac.coop, www.namac.mn хэлбэр, мэдээллийн шинэчлэлд анхаарч, бусад хүртээмжтэй цахим хуудсуудтай холбох, мэдээлэл тавих, ХАА-н хоршооллын салбарын талаарх цаг үеийн мэдээг олон нийтэд хүргэх, сурталчилж байх байнгын мэдээллийн сувгуудыг дэргэдээ байгуулан ажиллах нь чухал юм.

Байгууллагын амжилттай ажиллах, орчин нөхцлөө бодитойгоор үнэлэх, оновчтой шийдвэр гаргах үндэс нь судалгаан дээр тулгуурласан үйл ажиллагаа юм. Иймээс Үндэсний холбооны дэргэдэх Хоршооллын мэргэжил сургалтын төвийг өргөтгөн, “Судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв” болгон өөрчилж, тус төвөөрөө дамжуулан нийгмийн өмнө болон хоршооллын өмнө тулгамдаж буй асуудлын талаар судалгаа, шинжилгээ явуулж дүгнэлт зөвлөмжүүд гаргаж, дотоодын болон гадаадын донор байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж Үндэсний холбооны үйл ажиллагааг дэмжихэд томоохон үүрэгтэй аж ахуй болгон хөгжүүлэхийг зорьж байна.

2.4 ДӨРӨВДҮГЭЭР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. ХОРШООНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ

Зорилт: “Хоршооллын өсөлтийг дэмжсэн хууль эрх зүйн орчинг бий болгоно ”

Хоршооллын өсөлтийг дэмжсэн хууль эрх зүйн орчинг бий болгох асуудал нь зөвхөн манай орныхоршоодод тулгамдаж буй зүйл биш дэлхийн олон оронд тулгамдаад байгаа томоохон асуудал болоод байна. Иймд бид бодлого тодорхойлогчдод эрх зүйн орчноор хоршоодыг дэмжиснээр нийгэмд ямар ач холбогдолтой болохыг сайтар ухуулж, тэдний шийдвэр гаргалтанд нөлөөлж, хоршоодыг дэмжсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Төрийн чиглэсэн бодлого, эрх зүйн сайн зохицуулалт аливаа бизнесийн өсөлтийг хангахад чухал хүчин зүйл болдогийг анхаарч хууль, эрх зүйн таатай орчинг бий болгохыг манай Үндэсний холбоо эрхэмлэн ажиллана.

Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн асуудлыг Хоршооны тухай хуулиар зохицуулж байна. Засгийн газар “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр - II”-ыг батлаж, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар хоршооны нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, засгийн газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хэрэгжүүлж байна.

Тус зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Улсын их хурал, Засгийн газар, аймаг, нийслэлийн ИТХ-д хоршооны төлөөллийг өргөнөөр оруулж, хоршооны хууль эрх зүйн орчинг сайжруулах, төрийн бодлого шийдвэрийг хоршоодруу чиглүүлэхийг Үндэсний холбоо эрмэлзэнэ.

Хоршооны тухай хууль болон холбогдох бусад хуулиудад хоорондын зөрүүтэй заалтууд байгаа нь хоршооны хөгжилд муугаар нөлөөлж байна. Жишээлбэл: Монгол улсын Иргэний хуулийн 33.2.”Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.” гэсэн заалт, ААНОАТ-ын тухай хуулийн 5.3.1-д заасан татвар төлөгч аж ахуйн нэгжид мөн хуулийн 4.1.5-д зааснаар “ улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг;” гэсэн заалтууд ойлголцлын зөрүү үүсгэж байна. Хоршооны тухай хуулийн 37.1.7 “Хоршоодын холбоо нь хоршоодод нягтлан бодох бүртгэл хөтлөхөд нь мэргэжлийн туслалцаа үзүүлж, тайлан тэнцлийг шалгаж баталгаажуулна” гэсэн заалт Аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд “ Аудитын байгууллага нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа явуулах хувьцаат компани, хоршооноос бусад хэлбэрээр зохион байгуулагдсан аж ахуйн нэгж байна.” гэсэнтэй зөрүү үүсгэж байна. Энэ зөрүүтэй байдлыг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Хоршооны хөгжлийг дэмжсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс одоо мөрдөж байгаа 1995 онд батлагдсан Хоршооны тухай хуулийг шинэчлэн найруулахүйл ажиллагаанд Үндэсний холбоо мэргэжлийн байгууллагын үүднээс оролцоно.

Хоршоо бол гишүүдийн байгууллага. Гишүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлэх ажил үйлчилгээг хамтарч борлуулж, орлогоо хуваадаг болохоор хоршоо нь ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж үзсэн Иргэний хуулийн үзэл баримтлалыг үндэс болгон хоршооны гишүүддээ үзүүлж байгаа үйлчилгээнд НӨАТ оногдуулж байгаа доголдлыг арилгахын төлөө ажиллана.

2.5 ТАВДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ.**ХОРШООНЫ ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ**

Зорилт: “Гишүүдийн хяналт бүхий хоршооны хөрөнгийг бий болгоно”

Хоршоо бол ядуурлаас гарах, нийгмийн дундаж давхаргад шилжих гүүр юм. Хоршооны үйл ажиллагааг тогтвортой явуулахад хөрөнгө санхүүгийн чадвар, сайн засаглал, гишүүдийн оролцоо, итгэлцэл хамгийн чухал хүчин зүйлүүд болдог.Дээрх хүчин зүйлүүд дутагдалтай байвал хоршооны ирээдүйн хөгжил, үр өгөөжийг тодорхойлоход хүндрэлтэй юм.

Монгол улсын Хоршооны тухай хуулийн8 дугаар зүйлд хоршооны эд хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан байдаг. Үүнд:

8.1.1.Гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө

8.1.2.Дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар

8.1.3.Хоршооны үйл ажиллагааны орлогоос хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд хуваарилсан хөрөнгө

8.1.4.Бэлэглэсэн, хандивласан хөрөнгө

8.1.5.Хоршооны өмчлөл дэх бусад хөрөнгө зэрэг болно.

Хөдөө аж ахуйн хоршоодын дунд явуулсан судалгаанаас үзвэл нийт судалгаанд хамрагдсан хоршоодын 55.6% ньхөрөнгө, санхүүгийн хомсдолтой гэж хариулсан байдлаас харахад хөдөө аж ахуйн хоршоодод санхүү, хөрөнгийн оновчтой дэмжлэг дутагдалтай байгаа гэж дүгнэж болохоор байна.

Монголын санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд нь хоршоодын өмчлөлийн онцлогийг ойлгодоггүйгээсхоршоодод зээл өгөх сонирхол бага, олгосон зээлийнхугацаа богино, хүү өндөр байгаа нь хоршоодыг иргээд санхүүгийн хүндрэл, эрсдэлд оруулах нөхцөл болж байна.Харин хөрөнгө оруулагчдын хувьд зөвхөн санхүүгийн өндөр өгөөж өгдөг бизнест хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байдаг зэргээс шалтгаалан хоршоодын хувьд санхүүжилт олох нь хүндрэлтэй байна.

Хоршин ажиллаж байгаа гишүүд өөрсдийн боломжид баригдан бага хөрөнгөөр хувь нийлүүлж, цаашид тогтвортой ажиллах чадвараа хязгаарладаг хандлагыг өөрчилнө. Өөрийнхөө сайн сайхан амьдрал, амжилт бүтээлийн төлөө байгуулж байгаа хоршоогоо анхнаас нь зорилгынхоо дагуу ажиллах, эдийн засгийн чадавхийг гишүүд өөрсдөө бүрдүүлдэг байхыг чухалчилна.

Хоршоо хэдийгээр нийгэмд чиглэсэн бизнесийн хэлбэр хэдий ч ашигт ажиллагааг хангаж байх нь үйл ажиллагааг тэлэх, хөгжүүлэх гол нөхцөл нь болдог. Иймд холбоо, хоршоод хөрөнгө бүрдүүлэх гадаад болон дотоод нөөц боломжуудыг ашиглах, боломжит бүхий л арга хэлбэрээр хөрөнгө, санхүү бүрдүүлэхийн төлөө ажиллана.

Хоршоо бол дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн аж ахуй эрхлэх нэгэн хэлбэр тул үйл ажиллагаагаа өргөтгөхийн тулд бизнесээ хөгжүүлэх, ашгаа нэмэгдүүлэхийг зорихоос өөр аргагүй. Үндэсний холбоо болон гишүүн хоршоод хөрөнгө санхүүгийн хувьд хүчирхэг байж үйл ажиллагааны хэмжээ далайц нэмэгдэнэ. Иймээс Үндэсний холбооны дэргэдэх “Намак Кооп” ХХК, “Намак Хөгжил” ХХК-ний ажлыг шинэ түвшинд гаргах, бизнесийн шинэ төсөл, орон зайг идэвхитэй эрж хайх, хөрөнгө, санхүүгийн хувьд хөл дээрээ баттай зогсох зорилт хэрэгжүүлнэ. Ирээдүйд эдгээр байгууллагууд нь Үндэсний холбооны гол санхүүгийн түшиг тулгуур байх болно.

2.6 ЗУРГААДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ.ТӨР, ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилт: Төр, хоршооллын байгууллагын түшлэлийг бүх шатанд нэмэгдүүлнэ

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны бодлогод тусгагдсан хоршооллын салбар тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх

талын түншлэлийг хөхиүлэн дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болоход энэхүү бодлогын зорилго оршино.

Төр, хоршооллын салбарын түншлэлийг хөгжүүлэх нь Монгол Улсад сайн засаглалыг бэхжүүлэх, дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт нийцсэн хамтын хүчээр эдийн засгийг хөгжүүлэх Монгол Улсын төрийн бодлогын салшгүй хэсэг болох юм.

Тэргүүлэх чиглэлийн зорилт нь:

1. Төрийн түншлэлд тулгуурлан Хоршооллын байгууллага тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах
2. Төр, хоршооллын байгууллагын түншлэлийн хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, түншлэлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөх
3. Нийгэм, эдийн засгийн хөгжилд хоршооллын байгууллагын оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Төр, хоршооллын байгууллагын түншлэлийн бодлого нь хоршоодод тулгамдаж буй асуудлууд болон нийгмийн суурь үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх, Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хоршооллын байгууллага хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг Үндэсний холбоо болон хоршоодоор гүйцэтгүүлэх замаар тус салбар дахь төрийн оролцоог оновчтой болгох, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Гуравдугаар бүлэг.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЭГДҮГЭЭР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. ХОРШООНЫ УДИРДЛАГА, ГИШҮҮДИЙН ИДЭВХИ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Стратегийн зорилт.1 Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо Олон улсын болон дотоодын байгууллагуудад хамтарч ажиллах, оролцоогоо нэмэгдүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат	II үе шат
---	---------------------------	----------	-----------

		\2014-2018\	\2018-2022\
1.	Гишүүдийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалж, бодлого гаргагч нарт нөлөөлөн ажиллах, хоршооллын лобби бүлэг улс, аймаг, сумын түвшинд ажиллахад дэмжлэг үзүүлэх	+	+
2.	Олон Улсын Хоршооллын Холбоо, Азийн Фермерүүдийн Холбоо, Зүүн Азийн Хөдөө Аж Ахуйн Бодлогын зөвлөлд гишүүн байгууллагынхаа хувьд үйл ажиллагаагаа идэвхижүүлэх	+	+
3.	Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Олон улсын болон үндэсний хэмжээний уулзалт, хурал зохион байгуулах	+	+

Стратегийн зорилт 2. Хоршооны үйл ажиллагаан дахь гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Гишүүнчлэлийн оролцооны одоогийн түвшин, хэлбэрүүдийг судлах, оролцооны шинэ загваруудыг нэвтрүүлнэ	+	+
2.	Гишүүдийн ардчилсан оролцооны Дотоодын болон гадаадын тэргүүн туршлага, шинэ санаачилгыг судалж, хоршоодод нэвтрүүлнэ	+	+
3.	Гишүүнчлэлд тавигдах шаардлага, оролцооны систем, урамшууллын тогтолцоог тодорхойлсон бодлогын баримт бичиг боловсруулан мөрдүүлнэ	+	
4.	Хоршооны үйл ажиллагаан дахь гишүүдийн оролцооны талаар сургалт, мэдээллийг тогтмол чанартай явуулна	+	+
5.	Хоршоод хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцох болон бизнесийн туршлагаа хуваалцах, хамтарч ажиллах сүлжээг бий болгоно	+	

Стратегийн зорилт 3. Хоршоодын гишүүнчлэлийг нэмэгдүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
---	---------------------------	-------------------------	--------------------------

1.	Иргэдийн хоршооны талаарх ойлголт, түүнд хандах хандлагын түвшин, гишүүнчлэлээр элсэх сонирхолын талаарх судалгааг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна	+	
2.	Судалгааны мэдээлэлд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	+	
3.	Хоршооны ач холбогдол, мөн чанар, давуу талыг сурталчлах, түүнийг олон нийтэд хүргэх, хүртээмжтэй мэдээллийн сувгуудтай хамтран ажиллана	+	
4.	Залуучуудын гишүүнчлэлийн асуудалд онцгой анхаарах, залуу үеийг ХАА-н салбарт, тэр дундаа хоршооллын хөдөлгөөнд сайн дураараа нэгдэх үйл явцыг дэмжинэ	+	+
5.	Залуусыг хоршоололд татахад чиглэсэн зорилтод аянг үндэсний хэмжээнд өрнүүлнэ	+	

ХОЁРДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ **ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

Стратегийн зорилт 1.Хоршооллын байгууллагын эдийн засгийн орчинг сайжруулж, татварын бодлогоор дэмжихэд нөлөөлөх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	ХАА-н хоршооллын байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж нэвтрүүлнэ	+	
2.	Хоршоодын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө) , маркетингийн стратеги боловсруулж хэрэгжүүлнэ		
3.	Хоршоодын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулах борлуулалтын нэгжүүдийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулна Борлуулалтын сүлжээг байгуулах таатай орчныг бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> - Зах зээлийн багтаамжийн судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлнэ - Төвлөрсөн зах зээлд борлуулалтын суваг, худалдааны нэгж байгуулна - Бүтээгдэхүүн нөөцлөх стандартад нийцсэн нэгдсэн агуулах барина - Бүтээгдэхүүн борлуулалтын нэгжүүдтэй харилцаа 	+	+

	<p>тогтооход зуучилна</p> <p>Худалдан авагч үйлдвэрлэгчдийг холбох үйл ажиллагааг идэвхжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын менежментийг боловсруулан мөрдүүлнэ - Стандартыг хангасан бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тогтолцоо бий болгож, маршрут төлөвлөгөө боловсруулан ажиллана - Үйлдвэрлэгч, хэрэглэгчийг холбож, бүтээгдэхүүний чанар стандартад хяналт тавина 		
4.	Орон нутгийн төсөвт байгууллагуудын хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн худалдан авалтад хоршоодыгнийлүүлэгчээр оролцуулна	+	+
5.	Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт хийгддэг ажил, үйлчилгээг хоршоодоор гэрээгээргүйцэтгүүлнэ	+	+
6.	Хоршоодыг гадаадын болон дотоодын төсөл, тендерт оролцоход арга зүйн дэмжлэг үзүүлнэ	+	+
7.	ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд бэлтгэлийн чанар, ариун цэврийг сайжруулж, урамшуулал, эдийн засгийн хөшүүргийг ялгавартай болгоход анхаарч төрийн байгууллагуудтай хамтарч ажиллана	+	
8.	Хоршоогоор дамжуулан борлуулсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлогыг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх буюу уг татварыг төлөх орлогын босгыг нэмэгдүүлэх саналыг УИХ, Засгийн газраар шийдвэрлүүлэхэд нөлөөлнө		+
9.	Жилд нэг тэрбум хүртэл төгрөгийн борлуулалтын орлоготой ХАА-н хоршооны төлсөн орлогын албан татварын тодорхой хувийг буцаан олгох зохицуулалт хийхэд нөлөөлнө	+	
10.	Банк, Санхүүгийн байгууллагуудтай холбоо тогтоож, хамтарч ажиллах, хоршоодод хөрөнгө оруулалт, зээл, лизингийн үйлчилгээг нэвтрүүлэх	+	+
11.	Хоршооны тогтвортой хөгжлийн асуудлаар эрдэмтэд, судлаачид, ЭШБ-тай хамтарч ажиллах	+	+

Стратегийн зорилт 2. Хоршооны гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй болгох

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Гишүүдийг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах, хоршоо гишүүдийнхээ даатгалын хураамжийг төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгоно		+
2.	Хоршоод орон нутгийнхаа эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран жилд нэгээс доошгүй удаа гишүүдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг болох нөхцлийг бүрдүүлнэ	+	+

Стратегийн зорилт 3. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Хоршоологчдыг гадаадад урт, богино хугацааны сургалтуудад хамруулна	+	+
2.	Гадаадын хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтарсан аж ахуй байгуулж ажиллана	+	+
3.	Гадаадын донор байгууллагуудтай харилцаа тогтоож, ХАА-н хоршооллын байгууллагын хөгжлийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ	+	+
4.	Хоршоолол өндөр хөгжсөн орнуудын ХАА-н байгууллагуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ	+	+

Стратегийн зорилт 4.Хоршоодын удирдлага, хүний нөөцийг чадавхижуулах

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Аймаг, сумын түвшинд удирдлага, хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалт, мэдээллийн орчинг бүрдүүлнэ	+	+
2.	Хоршооллын салбарын хүний нөөцийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж цаашдын чиглэлийг тодорхойлно	+	
3.	ХАА-н хоршооллын салбарт нэн тэргүүнд хэрэгцээтэй байгаа мэргэжилтэний хэрэгцээ шаардлагыг тодорхойлно	+	
4.	Шинжилгээнд үндэслэн ХАА-н хоршооллын		

	байгууллад шаардлагатай, хөрвөх чадвартай мэргэжилтэн сургаж бэлтгэнэ	+	+
5.	Хоршооллын бүсчилсэн зөвлөгөөн, үзүүлэх сургууль, туршлага судлах гадаад, дотоод аялалууд зохион байгуулна	+	+
6.	Хоршооны дарга, менежер, нягтлан бодогч, тэргүүлэгчид, хяналтын зөвлөлд зориулсан сургалтууд явуулж, хөтөлбөр модулийг шинэчилэн, чанаржуулж байна	+	+
7.	Мэргэжилтэн бэлтгэх болон бусад сургалтуудад чиглэсэн материал, зөвлөмж, гарын авлага боловсруулна	+	+
8.	Хоршоодод зориулсан зайны сургалт, сургалтын модуль, төлөвлөөг боловсруулан хэрэгжүүлнэ	+	+

ГУРАВДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. **ХОРШООЛЛЫН НЭР ТӨРИЙГ ӨРГӨХ**

Стратегийн зорилт.1 Хоршоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Хоршоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чанар, стандартын шаарлага, хяналт тавьж ажиллана	+	+
2.	Шаарлагад нийцсэн бүтээгдэхүүнүүдэд нэгдсэн лого тэмдэгтийг байршуулна	+	+
3.	Нэгдсэн лого тэмдэгт бүхий бүтээгдэхүүнийг борлуулалтын нэгжүүдэд зуучлах буюу өөрийн борлуулалтын сувгаар борлуулна	+	+
4.	Хоршооны брэнд бүтээгдэхүүнийг нэгдсэн бодлогоор сурталчлах	+	+
5.	Хоршоодын үйл ажиллагааг эрсдлээс хамгаалах, даатгалт хамруулах	+	+
6.	Хоршоодын органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	+	+
7.	Төв, орон нутгийн үзэсгэлэн худалдаанд хоршоодыг зохион байгуулалттай тогтмол оролцуулна	+	+

Стратегийн зорилт 2. Мэдээллийн сувгуудаар дамжуулж хоршооны нэр төрийг өсгөх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	ХАА-н хоршооллын нэгдсэн лого тэмдэгтийг гишүүн холбоо, хоршоодын хүрээнд нэвтрүүлнэ	+	
2.	“Судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв”-өөр дамжуулан нийгмийн тулгамдаж буй асуудлын талаар судалгаа, шинжилгээ явуулж дүгнэлт зөвлөмжүүд гаргах, дотоодын болон гадаадын донор байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүд боловсруулан, хэрэгжүүлнэ	+	+
3.	www.namac.coop , www.namac.mn сайтуудыг сайжруулах, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөнө	+	+
4.	Хоршооллын байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг сурталчлан, борлуулах арилжааны цахим хуудас нээж, тус хуудсыг тогтвортой байдлыг хангаж ажиллана	+	
5.	Хоршоодын бүтээгдэхүүнийг өөрийн цахим хуудсаараа дамжуулан сурталчилаж, бусад хүртээмжтэй цахим хуудсуудад холбоос байршуулна	+	+
6.	Хоршооллын байгууллагын үйл ажиллагаа, ач холбогдлыг сурталчлаж, хүртээмжтэй олон нийтэд хүргэх мэдээллийн сувгийг байгуулна	+	
7.	ХАА-н чиглэлээр мэдээлэл түгээдэг бусад байгууллагуудтай хамтарч ажиллан, өөрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулна	+	
8.	Үндэсний холбооны дэргэд бие даасан маркетингийн албыг байгуулна	+	
9.	ХАА-н хоршоодыг үнэлэх үнэлгээний тогтолцоог бий болгож гишүүн хоршооддоо үнэлгээ хийснээр “ХОРШОО” нэр зүүж, хөдөлгөөний нэр хүндийг унагахаас хамгаална	+	+
10.	Тэргүүний хоршоо, хоршоологчдыг салбарын шагнал урамшуулалд хамруулахын зэрэгцээ төрийн нэр хүнд бүхий шагналуудад тодорхойлон шийдвэрлүүлнэ		

ДӨРӨВДҮГЭЭР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. ХОРШООНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ

Стратегийн зорилт 1. Хоршооллын байгууллагын эрх зүйн орчинг сайжруулахад нөлөөлөх

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Хууль санаачлагчид болон бодлого тодорхойлогчдод олон улсад мөрддөг хоршооныхууль, тогтоомжийн талаар судалгааг гарган хүргүүлнэ	+	
2.	Монгол улсын Их хурал, засгийн газар, аймаг нийслэлийн ИТХ-д хоршооны төлөөлөл, лобби бүлэг байгуулах, эрх зүйн болон бодлогын түвшинд нөлөөлнө	+	+
3.	Хоршоотой холбоотой Монгол улсын хууль эрх зүйн орчинд үнэлгээ хийж, хоршооны хөгжилд сөргөөр нөлөөлж буй заалтуудыг өөрчлөхөд нөлөөлж оролцоно	+	

ТАВДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. ХОРШООНЫ ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ

Стратегийн зоригт 1. Хоршооллын байгууллагын хөрөнгө оруулалт, зээлийн орчинг сайжруулах

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Донор байгууллагуудын хөрөнгө оруулалтыг өөрийн хоршооллын салбарт чиглүүлж, зээл, тусламж, санхүүгийн түрээсээр хоршоодыг дэмжинэ	+	
2.	ХАА-н хоршоонд зориулсан зээлийн батлан даалтын сан бий болгоно		+
3.	Хоршооллын банк, санхүүгийн байгууллага бий болгох боломжийг судлаж, дэргэдээ байгуулна		+
4.	Хоршоодод төсөл хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалт хийнэ	+	+
5.	Аймгийн сум хөгжүүлэх, ОНХөгжлийн сангийн тодорхой хувийг хоршоодод олгох байх орчинг бүрдүүлнэ	+	+

Стратегийн зорилт 2. Хоршооллын байгууллагыг материаллаг хөрөнгө оруулалтаар дэмжих

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат \2014-2018\	II үе шат \2018-2022\
1.	Холбоо, хоршоодын үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн байдлыг тодорхойлж, шаардлагатай байгаа	+	

	хөрөнгийн жагсаалт гаргана		
2.	Аймгийн холбоодын хөрөнгийг сайжруулж, эргэлтэнд оруулж санхүүжих боломжийг бүрдүүлнэ	+	
3.	Аймгийн холбоодыг санхүүжүүлэх бусад боломжуудыг судлаж, хамтран төсөл хэрэгжүүлэх байгууллагуудтай холбоно	+	+
4.	ХАА-н хоршоодод шаардлагатай техник тоног төхөөрөмжийг хөнгөлттэй нөхцлөөр нийлүүлэх санхүүгийн байгууллагуудтай гэрээ байгуулж, лизингийн үйлчилгээнд хамруулна	+	
5.	Түүхий эд бэлтгэлийн хоршоодод агуулах, тордолтын төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ	+	
6.	Анхан болон дундын хоршооны хүрээнд хамтарсан хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх санаачлагыг дэмжинэ	+	+

ЗУРГААДУГААР ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ. **ТӨР, ХОРШООЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Стратегийн зорилт:1. Төр, хоршооллын байгууллагын түншлэлийг бүх шатанд өргөжүүлнэ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	I үе шат (2014-2018)	II үе шат (2018-2022)
1.	Түншлэлийн арга, хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулна	+	+
2.	Түншлэлийн талаар баримтлах төрийн бодлогыг тодорхойлоход нөлөөлөх лобби бүлэг байгуулан ажиллана	+	
3.	Түншлэлийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд мэргэжлийн холбооны зүгээс ажиллана	+	
4.	Гэрээний үндсэн дээр төрийн зарим ажил, үйлчилгээг хоршооллын байгууллагуудаар гүйцэтгүүлэх үндэс суурийг тавьж, бэхжүүлнэ	+	+
5.	Төрийн зарим ажил, үйлчилгээг гүйцэтгэх үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлнө	+	+
6.	Хоршоодынтүншлэлд оролцох бололцоог тэргүүн	+	+

	ээлжинд дэмжих замаар тэдгээрийг санхүү, боловсон хүчнээр бэхжүүлэх, шинэ техник, технологиор хангахад чиглэсэн ажлууд зохион байгуулна		
7.	Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг гэрээгээр хамтран хэрэгжүүлнэ	+	+
8.	Төр, хоршооллын байгууллагын хамтарсан хуулийн этгээд байгуулах асуудлыг судлаж хэрэгжүүлнэ	+	+
9.	Түншлэлийг тогтвортой байдлыг хангаж ажиллана	+	+

Дөрөвдүгээр бүлэг.

ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын үе шат бүхэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан ашиглана.

Үндэсний холбооны Бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлснээр дараахь томоохон үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

(2014-2022 он)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ хоршоодын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, хоршооллын байгууллагын эдийн засгийн бүтцэд эзлэх байр суурь, хоршооны гишүүдийн нийгмийн асуудлууд сайжрах юм. Мөн санхүүгийн болон бүтээгдэхүүн борлуулалтын бүтэц байгуулах нь хоршооллын салбарт хамгийн ихээр тулгараад байгаа асуудлуудыг шийдвэрлэгдэх ач холбогдолтой. Баримт бичгийн гол үзэл баримтлал нь хоршооллын байгууллагыг хүчирхэгжүүлэх, Хоршооны олон улсын зарчим, мөн чанарыг хадгалсан хоршоодын эгнээг өргөжүүлэх, хоршооллын салбар дахь залуусын оролцоог дэмжих, хоршооллын байгууллагын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, хурдацтай хөгжлийг хангахад оршино.

Бодлогын баримт бичгийг Үндэсний холбоо болон аймгийн ХАА-н хоршоодын холбооны үйл ажиллагааны төлөвлөгөө, дэд хөтөлбөр, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Үндэсний холбооны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг жил бүрийн Удирдах зөвлөлийн хуралд тайлагнана. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2017 оны 1-р улирал)

II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2019 оны 1-р улирал)

III үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2021 оны 1-р улирал)

IV үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2023 оны 1-р улирал)

Хяналт, шинжилгээ, үнэлгээг Үндэсний холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэнэ.

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО